

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ  
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 04 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нараас 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 04 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Л.ЭНХНАСАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дарааж зүйл, хэсэг 19<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

~~1/19<sup>4</sup> дүгээр зүйл:~~

**“19<sup>1</sup> дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний байгууллагын шинжилгээ, судалгааны ажлын ил тод байдал**

19<sup>1</sup>.1. Энэ хуульд заасны дагуу хийгдсэн судалгаа, шинжилгээний бүтээлийг ажлын тайланг нэгтгэн хадгалж, олон нийтэд ил тод байдлыг хангахад чиглэсэн үндэсний судалгааны нэгдсэн цахим мэдээллийн сантай байна.

~~19<sup>4</sup>.2. Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд судалгаа хөгжүүлэлт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний мэдээллийг байршуулж, ил тод, аюулгүй байдлыг Заегийн газар хариуцна.~~

19<sup>1</sup>.2. Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага, зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

~~19<sup>4</sup>.3. Эрдэм шинжилгээний байгууллага нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд байршуулж, ил тод байлгана:~~

19<sup>1</sup>.3. Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд үг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана:

19<sup>1</sup>.3.1. энэ хуулийн 3.1.7, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 3.1.11-д заасан эрдэм шинжилгээний ажлын тайлан;

19<sup>1</sup>.3.2. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тайлан;

19<sup>1</sup>.3.3. тухайн байгууллагын судлаач, эрдэм шинжилгээний ажилтны эрдэм шинжилгээний бүтээлийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн;

19<sup>1</sup>.3.4. хуульд заасан бусад.”

~~2/23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг:~~

~~“23.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн өрөлцөөтэй хуулийн өтгөөдөөс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарласан сонгон шалгаруулалтад энэ хуулийн 3.1.11 т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн өрдөм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд төндөрийн болон гүйцэтгэлийн баталгаанаас чөлөөлнө.”~~

~~3/23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг:~~

~~“23.5.Төрийн өмчит өрдөм шинжилгээний байгууллагын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад өрөлцөж бий болгосон бүтээлийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд өрдөм шинжилгээний бүтээлийн нэгдсэн еанд байршуулна.”~~

~~2 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:~~

~~“18.2.2.Дээд боловсролын тухай хуулийн 4.1.4 т заасан судалгааны их сургууль;”~~

~~2 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн” гэснийг хассугай.~~

~~4 дүгээр зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.~~

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд дараах агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй **доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:**

**1/3 дугаар зүйлийн 3.3.8 дахь заалт:**

~~“3.3.8.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 23.4 д заасан төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хөрөглөөний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх харилцаа.”~~

**1/14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг:**

~~“14.9.Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад энэ зүйл хамаарахгүй.”~~

**2/42 дугаар зүйлийн 42.10 дахь хэсэг:**

~~“42.10.Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад энэ зүйл хамаарахгүй.”~~

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй:

“5/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар академийн харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцох.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл. Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

Гарын үсэг